

“Том төрөөс ухаалаг төр рүү”
санаачилгыг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилгыг дэмжиж, судалгаанд суурилсан, үйлчилгээнд чиглэсэн, хууль дээдэлсэн ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчид:

1. Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, манлайллаар хангаж ажиллах.
2. Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх үндэсний болон улс төрийн зөвшилцлийг бүрдүүлэх.

Хоёр. Монгол Улсын Их Хуралд:

1. Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэн яаралтай хэлэлцэн батлах.
2. Хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ухаалаг төрийн зарчмыг баримтлах, түүнд нийцээгүй хууль тогтоомжийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Гурав. Монгол Улсын Засгийн газарт:

1. Бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон хууль санаачлах, шийдвэр гаргахдаа ухаалаг төрийн зарчмыг гүйцэтгэх засаглалын бүх шатанд чанд баримтлах.
2. Бизнес, эдийн засгийг идэвхижүүлэх, эдийн засгийн гадаад хамаарлыг багасгах, үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах.
3. Иргэд, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд төрийн шаардлагатай ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг хэмнэлттэй, үр ашигтай болгох.

4. Төрийн өмчийн барилгыг тодорхой нөхцөлөөр худалдах, хувийн өмчийн барилгыг түрээсээр ашиглах замаар тодорхой яам, агентлаг, төрийн байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн байршил, үйлчилгээ, сүлжээнд хамруулах.

5. Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн нэгдсэн санг бүрдүүлж нээлттэй бөгөөд бүртгэл, хяналттай болгох.

6. Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, цаашид ийм шийдвэр гаргуулахгүй байх.

Дөрөв. Төрийн байгууллагуудад:

Байгууллагадаа ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явуулж, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тодорхой ажлыг хариуцах эзэн, тодорхой хугацаатайгаар тусган хэрэгжүүлж, дээд шатны болон аудитын байгууллага, олон нийтэд тайлагнах.

Тав. ҮАБЗ-ийн Нарийн бичгийн даргад:

Энэ зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллах.